



Tradition and present of pedagogical knowledge of Mongolians

Tsanjid Ayurzana

Article information	ABSTRACT
<p>Article history:</p> <p>Received: 2024.11.05 Revised: 2024. 11.18 Accepted: 2024.11.20</p>	<p>Since a long time ago, Mongolians have had a tradition of educating the young and next generations and preparing them for life. Apparently, the tradition has its philosophical foundation, which is traditional knowledge inheritance. Examining and utilizing traditional knowledge is significant to preserve environmental sustainability, adapt climate, protect biological diversity, preserve and utilize cultural heritage, create new medical treatment and medicine, reduce risk of natural disasters, which lead to sustainable economic growth. Traditional knowledge contains knowledge and methods and technology to use the knowledge. Traditional knowledge develops over a long period of time and is consistent with the local environment and characteristics, culture, and personality of ethnicities in the region, and concerns a sustainable future. The ways Mongolians interact with nature and carry out agricultural works are strongly associated with pedagogical knowledge. Present time, it is crucial to utilize experiences and achievement of traditional knowledge to advance science and technologies and solve challenging problems in today's society. Traditional pedagogical knowledge has its principles and both pedagogical and psychological instruments. The instruments are to give oral instructions, assign games and tasks to complete while methods include moralizing, encouraging and blaming but not limited to. Traditional pedagogical activities educate learners to be "human being" and place greater emphasis on holistic development of learners, cultivating their intelligence, emotion and physical development. Furthermore, Mongolian traditional pedagogical knowledge and heritage has potential to grow pivotal virtues, skills and competencies in modern world including problem-solving skill, creative thinking, positive attitude towards ecology and morality so on. Besides, Mongolian educational philosophy needs to creatively integrate the heritage of traditional pedagogical knowledge, accumulated experiences of the socialist period, and modern trends of educational transformation. In addition to the above, it is crucial to consider three common directions, which include ensuring national security, preparing competitive human resources for the global market, and nurturing global Mongolian citizens.</p>
<p>Keywords:</p> <p>Philosophy Traditional pedagogical knowledge tradition Mongolian education Heritage</p>	<p>Corresponding author:</p> <p>Tsanjid Ayurzana Email: ayurzana88tsanjid@gmail.com</p>

Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлал ба өнөө үе

Аюурзанын Цанжид

Санал болгож буй эшлэл:

Цанжид, А. (2024). Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлал ба өнөө үе. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.03>

To cite this article:

Tsanjid, A. (2024). Tradition and present of pedagogical knowledge of Mongolians. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.03>

МОНГОЛЧУУДЫН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААНЫ УЛАМЖЛАЛ БА ӨНӨӨ ҮЕ

Орчин үед уламжлалт мэдлэг ухааныг өнгөрсөн үеийн төөрөгдөл, алдаатай мэдлэг гэх юм уу, орчин үед ач холбогдолгүй гэж үзэхээ больж байна. Уламжлалт мэдлэг ухааныг судлан ашиглах нь байгаль орчны тогтвортой байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янз байдлыг хамгаалах, соёлын өвийг хадгалах, ашиглах, эмчилгээний шинэ арга, эм бүтээх, гамшгийн эрсдэлийг бууруулах, улмаар энэ бүхний үр дүнд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэх боллоо. Биологийн олон янз байдлын тухай конвенцид “Уламжлалт мэдлэг гэдэг нь дэлхий дахины уугуул ард түмэн болон орон нутгийн хүй элгэний мэдлэг, инновац болон практик мөн. Тэдгээрийг олон зууны туршид хуримтлуулсан туршлагаас буй болгож, тухайн нутгийн соёл, хүрээлэн буй орчны нөхцөлд зохицуулан үеэс үед амаар дамжуулдаг. ... түүх, дуу, язгуур урлаг, зүйр цэцэн үг, соёлын үнэт зүйлс, орон нутгийн хэм хэмжээнүүд, хэл, газар тариалан мал аж ахуй эрхлэх зэрэг хөдөө аж ахуйн үйл ажиллагааны хэлбэртэй байдаг” гэжээ (Convention on Biological Diversity, 2006). НҮБ-ын уугуулын асуудлаарх байнгын форумын баримт бичигт дурдахдаа “Уламжлалт мэдлэгийн үнэ цэнийг улам бүр хүлээн зөвшөөрөх боллоо. Уламжлалт мэдлэг нь өдөр тутмын амьдралдаа түүнийг хэрэглэдэг хүмүүст төдийгүй, орчин үеийн хөдөө аж ахуй, аж үйлдвэрт ч үнэ цэнтэй. Энэ нь тогтвортой хөгжилд, цаг уурын өөрчлөлт, газрын менежмент, ой хамгаалах зэрэг нийтлэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон эмийн үйлдвэрлэлийн жишээнээс үзэхэд шинжлэх ухаан, технологийн анагаах ухааны судалгаануудыг эрчимжүүлэхэд чухал үүрэгтэй байна” гэжээ (The United Nations Permanent Forum on Indigenous Issues. Together We Achieve).

Уламжлалт мэдлэг ухаан гэдэгт мэдлэг болон түүнийг хэрэглэх арга, технологи багтаж байгаа юм. Уламжлалт мэдлэг ухаан нь нэгд, олон жилийн туршлагаар шалгарсан байдаг, хоёрт, тухайн орон нутгийн байгаль орчны нөхцөлд нийцсэн байдаг, гуравд мөн тэр нутгийн үндэстэн, ястны соёл, зан чанарт нийцэж тохирсон байдаг, дөрөвд агуулгадаа тогтвортой ирээдүйг харгалзсан байдаг зэрэг онцлогтой.

Дээр дурдсан баримт бичгүүдэд сурган хүмүүжүүлэх мэдлэг ухааныг нэр заан дурдаагүй боловч, байгаль орчинтой харьцах, хөдөө аж ахуйн хэлбэртэй үйл ажиллагаа явуулах гэх мэт болон орон нутгийн хэм хэмжээг буй болгох, мөрдөх зэрэг нь сурган хүмүүжүүлэх мэдлэг ухаантай салшгүй холбоотой байдгийн дээр ямар ч ард түмэнд залуу үеэ сургах, хөгжүүлэх, ирээдүйн амьдралд нь бэлтгэх биеэ даасан мэдлэг ухаан байдаг билээ.

Орчин үед шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд уламжлалт мэдлэг ухааны ололт, туршлагыг ашиглах нь чухал болж байна.

Монголчуудын хувьд хүүхэд, залуусаа хүмүүжүүлэх, хөгжүүлэх арвин баялаг уламжлалтай юм. Үүнийг манай боловсролын салбарын мэргэжилтэн судлаачид “ардын сурган хүмүүжүүлэх зүй” нэрээр судалж, зохиол бүтээлээ турвисаар ирсэн байна. “Ардын сурган хүмүүжүүлэх зүй гэж ерийн нэгэн хэсэг бусад хар ухаан биш, сургалт хүмүүжлийн ажлын зорилго, агуулга, хэрэглүүртэйгээр барахгүй, бас өөрийн онцлог, өөрийн гүн ухаан, сэтгэл судлалын үндэснээс урган гарсан тогтолцоот ухаан” ажээ (Г.Эрдэнэ-Очир, 1979, х.7).

Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухаан нь өнөөгийн нэр томъёогоор гүн ухаан, сэтгэл зүйн онолын үндэслэлтэй гэж болмоор. Эрдэнэ-Очирын “тогтолцоот” хэмээн тодотгож байгаа нь бүрэн үндэстэй юм. Учир нь уламжлалт сурган хүмүүжүүлэх ухаан тодорхой зарчмуудад тулгуурладаг, сурган-сэтгэл зүйн гэж болох арга хэрэгсэлтэй байжээ. Тухайлбал, тулгуур зарим онцлог зарчмыг нь дурдъя.

- Хүүхдийн хүмүүжил төлөвшлийг эрт бага наснаас нь эхлэх. Тухайлбал, хүүхдийг бүр эхийн хэвлийд байх үеэс нь хүмүүжил, төлөвшилд нь анхаарал тавьдаг байх учиртай хэмээн үзэж байжээ. Энэ талаар Ч.Бат-Очирын бичсэн нь “Анхан эхийн умайд биеийн дүрсийг олсон цагт мэргэн эх нь бие шалтгаантай болоод сац хажуулан асуухгүй, далжийн суухгүй, хэлбийж зогсохгүй, нийлэмжгүй юм идэхгүй, ... исэр төвгүй бол суухгүй, нүд муу өнгийг үзэхгүй, чих хурьцангуй дууг сонсохгүй, өглөө үдэш уянгат шүлэглэлийг дуудуулан төв чигч хэргийг хэлүүлэн сонсож явбаас хөвгүүн төрөөд байдал төлөв төв, шударга, эрдэм хүнээс илүү болмуй” хэмээжээ. Монголчууд “хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” хэмээн үзэж хүүхдийг мэдээ орсон цагаас нь сургаж хүмүүжүүлдэг байжээ. Ямар хүн болж өсөж төлөвших ёстойг бага наснаас ухамсарлуулж, хүүхдийг сэвлэгээ үргээлгэх цагт нь “ номд мэргэн, нойронд сэргэг,

үйлэнд уран, үгэнд цэцэн, ээж аавдаа ачлалтай, элгэн түмэндээ тустай, төрдөө түшигтэй” гэх мэтээр ерөөн сургамжилдаг байна.

- Сургах хүмүүжүүлэхдээ олон янзын арга хэрэгслийг хослуулдаг байв. Хэрэгслийн хувьд аман сургаал айлдах, ажил үйл гүйцэтгүүлэх, тоглоом тоглуулах гэх мэт. Аргын хувьд сургамжлах, зэмлэх, урамшуулах зэргээр нөлөөллийн олон аргыг хэрэглэх.
- Хүүхдийн хүмүүжилд орчин нөлөөтэй болохыг ухаарч уг ажилд гэр бүл төдийгүй айл саахалт, нутаг усныхан оролцож, сургах, заах, зэмлэх, үлгэр үзүүлэх гэх мэтийн олон аргыг хэрэглэнэ.
- Хүүхдийг хөдөлмөрөөр сургахыг онцгой ач холбогдолтой гэж үзнэ. Хүүхэд “аяга даадаг” болсон үеэсээ хөдөлмөр хийх ёстой. Үүнийг яруу найрагч Т.Галсан дараах байдлаар тоймлон хэлсэн байдаг.

1-3 насандаа ээждээ аргал хомоол, аяга шаазан дөхүүлж өгөх,
4-5 насандаа хургачин,
5-6 насандаа тугалчин,
6-8 насандаа ботгочин,
8-16 насандаа хоньчин,
17 ба дээш насандаа адуучин.

Хүүхдийн бие бялдрын өсөлт, чадварт нийцүүлэн ажил хөдөлмөр хийлгэдэг байна.

- Хүүхдэд биеэр үлгэрлэх. Энэ нь ажил хөдөлмөрт сургахаас эхлэн хүнтэй харьцах, ёс заншил дагах гэх мэт хүүхдийн хөгжлийн бүхий л талыг харгалзсан байдаг. Тиймээс ч “эх нь хээр алаг бол, хүү нь шийр алаг гэж” хэлэлцдэг.
- Ганцаарчилсан хэлбэртэй.

Боловсролын зорилго нь түүний агуулгаар тодорхойлогдож байв. Монголчуудын гэрийн хүмүүжил боловсрол нь нэгд, ажил хөдөлмөрийн мэдлэг, дадлагатай болгож, хожим амьдралаа өөрөө бие даан авч явах чадвартай болгох, хоёрт, эрүүл мэндээ хамгаалахын зэрэгцээ гэр бүл зохиож, үр хүүхдээ эрүүл энх өсгөн бойжуулах, гуравд, нийгэм дотор биеэ зөв авч явж, бусадтай харилцаж, хамтран аж төрөх чадвартай болж нийгмийн харилцаанд ороход бэлтгэдэг байсан байна. Нийгмийн өөрчлөлтийн хэрээр эдгээр үүргийн зарим хэсгийг сургууль боловсролын байгууллага болон нийгмийн бусад институтууд гэр бүлтэй хамтран хүлээдэг болсон боловч хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааны энэ гурван үндсэн чиглэл өөрчлөгдөөгүй. Харин хүүхдийн боловсрол, хүмүүжилд оролцогчид эдгээр үүргийг биелүүлэхэд ямар оролцоотой байх, хоорондоо хэрхэн үр нөлөөтэй хамтран ажиллах вэ гэдэг нь тэр бүр шийдвэрлэгдээгүй, улмаар залуу үеийг төлөвшүүлэх асуудалд янз бүрийн доголдол гарсаар байгаа юм.

Уламжлалт сургалт хүмүүжлийн ажил нь орчин үеийн нэр томъёогоор яривал хэд хэдэн тодорхой чадамжийг эзэмшүүлэхэд чиглэж байсан байна. Үүнд

- Ажилсаг байх. Цаг хугацааг хий дэмий нөхцөөдөггүй, эртэч байх, юмхнаар юм хийх, “суусан газраасаа шороо атгах” гэх мэт.
- Хөдөлмөр эрхлэх. Үүнд мал маллах, газар тариалан эрхлэх, малын болон газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах, аян жин тээх, малын тоног төхөөрөмж хийх, гэрээ сэлбэн засах, дээл хувцас оёх, хоол, цай хийх гэх мэт.
- Ёс суртахууны хэм хэмжээг эзэмшүүлэх. Уламжлалт зан заншлыг мөрдөх, ахас ихсийг хүндлэх, хүн болон мал амьтанд энэрэнгүй хандах, бусадтай эвтэй найртай байх, тэдэнд тусалж, дэмжих.
- Бэлгэдэлт сэтгэлгээг төлөвшүүлэх.
- Байгаль орчинтой зүй зохистой харьцах. Булаг ус бохирдуулах, газрыг зорилгогүйгээр сэндийчихгүй байх, ан гөрөө хийхэд тодорхой хэмжээ баримтлах, ёслол үйлдэх, хэрэгцээнээсээ илүү юмыг байгалиас авахгүй байх гэх мэт. Мөн байгалийг хүндэтгэж харьцах.

- Эрүүл мэндээ хамгаалах, бусдыг асарч халамжлах.

Эдгээр нь тухайн үеийн амьдралын хэрэгцээнд нийцсэн бөгөөд нийгмийн уламжлалт дүр төрхийг үеэс үед хадгалж нөхөн үйлдвэрлэхэд чиглэсэн чадамжууд юм. Аливаа нийгэм харьцангуй хөдлөнгө байх үедээ ч өөрийгөө хадгалах эрмэлзэлтэй байдаг учраас эдгээр чадамжууд нь аль цаг үеийн хүнд байвал зохих суурь чадамж хэмээн үзэх нь зохистой юм. Эдгээр таван зүйлийг ажиглахад энэ нь өнөөдөр XXI зуунд хэрэггүй гэж хэлмээр зүйл ажиглагдахгүй байна.

Монголчуудын хүүхэд, залуучуудыг сурган хүмүүжүүлэхдээ баримталж ирсэн эдгээр зарчмыг уг ажлын тогтолцооны шинж хэмээн үзэж болох юм. Түүнээс гадна сурган хүмүүжүүлэх тодорхой арга хэрэгсэлтэй байсаар ирсэн юм. Тэдгээрийг дотор нь дараах байдлаар ажиглаж болно. Үүнд:

- Аман сургаалаар хүмүүжүүлэх
- Үйлдлээр заан сургах
- Тоглоом наадгай ашиглан хөгжүүлэх
- Үндэсний урлаг, спортыг ашиглан хөгжүүлэх гэх мэтээр ангилж болно.

Эдгээр нь дотроо олон төрөлтэй бөгөөд төрөл тус бүр нь хүмүүжил, хөгжлийн тодорхой нөлөөтэй байдаг. Сургалт, хүмүүжлийн арга хэрэгсэл бүр цогц шинжтэй байдаг нь онцлог юм. Өөрөөр хэлбэл, биеэр үйлдэх үйлдэл, дуу, шүлэг зэрэг олон төрлийн хэрэгсэл нэгэн зэрэг хэрэглэгдэж оюун ухаан болон сэтгэл хөдлөлийг юм уу эсвэл бие бялдрыг зэрэг хөгжүүлж байдаг. Жишээлбэл, оньсого таалгах нь оюун ухааныг хөгжүүлэх зорилготой боловч бас сэтгэл хөдлөлөө зөв байлгах, биеэ барихад сургадаг. Учир нь хүн оньсогог таагаагүй бол түүнийг таалгасан хүн худалддаг заншилтай. Тэгэхдээ эхлээд оньсого таалгаж буй хүн:

Бушуу түргэн таавал чинь
Буурал мориноосоо бууж өгье.
Булган дахаа тайлж өгье.
Үрээ мориноосоо бууж өгье.
Үнэгэн дахаа тайлж өгье

гэх мэтээр ам өгөөд, харин таагаагүй тохиолдолд:

Ингэн ингэн тэмээнээс
Ерэн уут шорооноос
Тайлаг тайлаг тэмээнээс
Таван уут шорооноос
Сиймхий хадгаас
Сэтэрхий гэвнээс
Бор нохойн богтосноос
Шар нохойн шаантаас
Бөөн бөөн өөхнөөс
Бүдүүн нарийн хошногоноос
Чамайг худалдана гэх мэтээр хорыг нь малтдаг.

Эцэг эх, ахмад хүмүүс энгийн яриагаар ухуулж, сэнхрүүлэхдээ үлгэр домог, зүйр цэцэн үг гэх мэт аман соёлын маш олон төрөл зүйлийг хэрэглэнэ. Бидний бага ахуй үед томчуудын амнаас өдөр тутам зүйр цэцэн үг сонсдог байсан. Аман сургаалын төрөл зүйлүүд нь тус тусдаа өвөрмөц үүрэгтэй байдаг нь ажиглагддаг.

Хүснэгт 1. Аман зохиолын төрөл зүйл

Үлгэр	Сайн үйлийг дуурайлгах, муу үйлд жигшүүлэх. Ажилсаг, ухаалаг, найрсаг гэх мэт хүний сайн чанарыг ухуулсан шинжтэй.
Домог	Дээр дурдсанаас гадна урдын явдлыг сануулж, зан заншлыг уламжлуулах үүрэгтэй.
Тууль	Дээрх үүргүүдээс гадна байгаль дэлхийгээ хүндэтгэх, шүтэх хүмүүжил олгох, сэтгэл зүйн засал хийх гэх мэт болон бусад
Зүйр, цэцэн үг	Юмс үзэгдлийн мөн чанарыг таниулах, сэтгэлгээг хөгжүүлэх, ухааруулах

Онъсого таавар	Оюун ухааныг хөгжүүлэх, төвөгтэй нөхцөлд шийдэл олох чадварыг хөгжүүлэх
Түргэн хэллэг	Хүүхэд залуусын хэлийг зүгшрүүлэх
Дайралцаа	Түргэн сэтгэх, хэл яриаг хөгжүүлэх, сэтгэл хөдлөлийг төлөвшүүлэх

Энэ мэтээр сурган хүмүүжүүлэх аман сургаалын арга барил маш олон янз. Дууны үг хүртэл сургамжилсан, гүн гүнзгий философи агуулгатай байдаг.

Төрөл бүрийн тоглоом нь сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой чухал хэрэгсэл байсаар ирсэн юм. Хамгийн энгийн чулуун гэр барих тоглоом гэхэд л гэрийн дотор хаана юу байдгийг мэдүүлэхээс эхлэн гэр бүлийн гишүүдийн үүрэг, харилцаа хүртэлх нарийн ширийн зүйлийг таних боломж олгодог. Дээр дурдсан үгэн тоглоомоос гадна шагайн тоглоом, хөлөгт тоглоомууд, онъсон тоглоомууд нь оюун ухаан, ой тогтоолт, сэтгэл хөдлөлийг хөгжүүлэхэд ихээхэн үүрэгтэй байжээ.

Дүгнэж хэлэхэд уламжлалт сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь хүүхдийг хүмүүжүүлж, “хүн хийхээс” гадна, түүнийг оюун ухаан, сэтгэл хөдлөл, бие бялдрын хувьд хөгжүүлдэг байсан байна. Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны өвийг философи талаас нь ойлгох гэвэл юуны өмнө нэг зүйл тодорхой ажиглагддаг. Энэ бол насанд хүрсэн хүн буюу сургалт хүмүүжлийн ажлын үр дүнд буй болсон хүн олон талын чадвартай “нэгэн цул” байх ёстой гэх үзэл юм. Энэ нь жишээ нь дээр дурдсанчлан хүүхдийг “номд мэргэн, нойрт сэргэг, далайд усч, дайнд баатар” гэх юм уу “үйлэнд уран, үгэнд цэцэн” гэх мэтээр ерөөдөг, “эр хүн наадамд гурван даваатай, найранд гурван дуутай байх”, эмэгтэй хүн хэрвээ шаардлага гарвал “гэрт орж эм, гадаа гарч эр” болж чаддаг байх гэх мэтээр илэрдэг гэж болох юм. Монгол хүн ийм байхыг амьдралын нөхцөл нь шаарддаг байжээ. Тиймээс монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны философи идеал нь “арван хуруу тэгш”-ийн зарчим гэж болох юм.

Монголчууд хүүхдээ төрсөн цагаас нь эхлэн өдөр тутам гэр бүл, нутаг нугын хүрээнд, ажил, амьдрал дунд ийнхүү сургаж хүмүүжүүлдэг байснаас гадна жинхэнэ боловсролын гэмээр сургалтын хэлбэр байсныг тэмдэглэхгүй орхиж болохгүй юм. Энэ нь бас дотроо хоёр хэлбэртэй байсны нэг нь гэрийн сургалт, нөгөө нь сургууль юм. Гэрийн сургалт чухам хэдийнээс үүссэн бэ гэдгийг тогтоох аргагүй юм. Бүр Хүннү гүрний үед түшмэлүүдэд татвар авахын тулд данс хөтлөх аргыг хятад түшмэлээр заалгаж байсан гэх түүхийн мэдээг баримталбал, гэрийн сургуулийн үүслийг тэр үеэс тооцож болох талтай. Хожим Сяньбийн үед сяньби хэл бичгээ заадаг байсан тухай түүхэнд бас дурдагдсан байдаг. Их Монгол Улсын үед гэрийн сургалт төдийгүй сургууль олноор байгуулагдаж байсан билээ. Их Монгол Улсын дараах үед Монголд сургууль ажиллаж байсан тухай мэдээ байхгүй боловч гэрийн сургалт тасраагүй үргэлжилж байсан ажээ. XVII зууны эхээр өмнөд монголоор жуулчилсан Ся Да хянь “бичиг үсэг уншиж бичиж чаддаг хүнийг багш гэх ба бичиг үсэг заалган буй хүнийг шавь гэнэ” (Ш. Бирагаас дам эшлэв) гээд багш шавь болох ёсны талаар бичсэн байдаг байна. Ар Монголын тухайд гэвэл 1700-аад оны дунд үеэс бичгийн сургуулиуд байгуулагдаж эхэлсэн байдаг. Энэ уламжлал тасралтгүй үргэлжилсээр өнөө ардын хувьсгалтай золгосон байна. Гэрийн сургалт ч байнга байсаар иржээ. Гэвч харамсалтай нь, тэр үеийн сургууль боловсролын ажлын талаарх бодлого, философийг нарийвчлан судлах боломж хомс юм. Гэрийн сургуулийн уламжлалаар буй болсон нэг чухал ойлголт-зарчим бол багш шавийн барилдлага юм. Энэ нь зөвхөн бичиг заах-заалгах тухай асуудал бус, багш нь шавиа хайрлах, түүнийг хүний нь хувьд төлөвшүүлэх, өөрөө үлгэрлэх, шавь нь багшаа хүндэтгэх гэх мэтийг багтаасан маш өргөн агуулгатай байжээ. Үүнээс үүдэн багш хүн мэдлэг чадвартай, өндөр ёс суртахуунтай байх, шавь нь хичээнгүй байх гэх мэт шаардлагууд тавигддаг нь тэр үеийн гэрийн боловсролын философийн үндэс гэж болох юм.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлал өнөөдөр хэр үнэ цэнтэй вэ, түүнийг ашиглах боломж, хамгийн гол нь үр нөлөөтэй юү гэдэг асуулт гарна. Миний бодлоор эдгээр асуулт бүгд эерэг, тийм гэсэн хариулттай. Энэхүү хурал намайг эл сэдвээр илтгэл тавиарай гэснийг бодоход сүүлийн нэг жилд нэлээд яригдаж байгаа монголын боловсролын философийг боловсруулахтай холбоотой байх хэмээн таамаглаж байна. Дээр дурдсан зарчмуудыг боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд ашиглах бүрэн боломжтой юм. Эдгээрийг чухамдаа монгол боловсролын философийн тулгуур зарчмууд хэмээн үзэж болох юм. Харин сурган хүмүүжүүлэх уламжлалт арга хэрэгслийг хичээл заах, сурах бичгийг зохиомжлох гэх мэтээр сургалтын үйл явцад ашиглах боломжтой юм. Ялангуяа сургуулийн өмнөх боловсрол болон бага сургуулийн сургалтад эдгээр аргыг шууд хэрэглэж болно. Харин дунд ахлах ангид хэрэглэх арга зүйг

нэлээд судалж боловсруулах хэрэгтэй юм.

Сурган хүмүүжүүлэх монгол өв уламжлал нь орчин үед хүүхэд залуучуудад эзэмшүүлэхийг онцолж байгаа асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч сэтгэлгээ, экологийн зөв хандлага, ёс суртахууны шилдэг чанарууд зэрэг чадамж болон шинжийг бүрдүүлэх чадвартай юм. Жишээ нь, чоно, ямаа, өвс гурвыг голоор гаргах тухай гэх мэт бодлогууд нь хүүхдэд бэрхшээлтэй байдлаас оновчтой шийдвэр олж гарах аргад сургадаг бол математикийн хичээлээр тэгшитгэл зохиож бодмоор бодлогыг цээжээр бодуулдаг бодлогууд байдаг. Жишээ нь,

1. Айлын отгон хүү “миний ах эгч нарын тоо адилхан” гэж хэлэхэд отгон охин нь “би эгч нараасаа 2 дахин олон ахтай” гэжээ. Тэр айл хэдэн хүүхэдтэй вэ? (7, отгон хүүгийн хэлснээр бол 3 ах, 1 дүү, 2 эгчтэй бол отгон охины хэлснээр 4 ах 2 эгчтэй).
2. Найман шанага сүүг тав ба гурван шанага сүү багтдаг хоёр саваар хэрхэн тэнцүү хуваах вэ? (олоорой)

Энэ мэт бодлого, таавар нь оновчтой шийдэл гаргах чадварт сургахын зэрэгцээ оюун ухааныг ерөнхийд нь хөгжүүлж байдаг. Эдгээрээс гадна янз бүрийн эвлүүлэх тоглоомууд, зангилаа, сүлжээ, гогцооноос чөлөөлөх тоглоомууд бий. Эдгээр нь бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд нөлөөтэй байдаг байна.

Тийм учраас монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны өв уламжлалыг өнөөгийн нөхцөлд бүтээлчээр ашиглах боломж дүүрэн бий. Гагцхүү хичээл бүрээр ямар зорилгоор, ямар сэдвийг судлахад, хэрхэн хэрэглэх вэ гэдгийг бодож боловсруулах хэрэгтэй юм.

Монголчуудын сурган хүмүүжүүлэх ухааны өв уламжлалыг үндсэн зарчим болон арга барилын талаас нь авч үзвэл ийм байна.

Тэгвэл нөгөө талаас дэлхийн боловсролын философийн шинэ парадигмд юуг онцолж байна вэ?

- Боловсролын зорилгын өөрчлөлт: Мэдлэг чадвар олгохоос чадамж бүрдүүлэхэд шилжих,
- Сургалтын агуулгын өөрчлөлт: салгуу олон хичээлээс суралцагчдын чадамжийн суурь болж чадахуйц өөр хоорондоо уялдаа бүхий системт агуулгыг бүрдүүлэх,
- Багшийн арга барилын өөрчлөлт: лекцлэхээс харилцан ярилцах, туршилт хийх, төсөл хэрэгжүүлэх гэх мэт янз бүрийн аргаар мэдлэгийг хамтран бүтээгч байх,
- Сургуулийн орчны өөрчлөлт: тэргүүний технологийг нэвтрүүлэх замаар бодит болон виртуал орчинд суралцах, бие даан суралцах, суралцагчдад сонголттой суралцах, олон эх үүсвэрээс суралцах боломж олгохуйц шинэ орчныг бүрдүүлэх,
- Насан туршийн тасралтгүй боловсрол
- Бие даах, ганцаарчилсан суралцахуй гэх мэт.

Боловсролын шинэ парадигмын үндсэн зарчмууд хэмээн тоочоод байгаа эдгээр болон бусад зүйлсээс харахад энэхүү парадигм нь экзенталист-диалогийн, антропологийн, шүүмжлэлт гэх мэт өмнөх үеийн боловсролын философийн хэд хэдэн чиглэлийн найрсал маягтай харагдаж байгаа юм.

Тэгэхдээ бид зөвхөн уламжлалт өвд суурилан шинэ философийг буй болгох гэж байгаа биш юм. Энэ хоёрын завсар социализмын үеийн боловсрол гэж буй юм. Энэ үеийн боловсролын философид давуу болон сул тал нь юу байсан бэ гэдгийг ч бас тунгаах ёстой. Учир нь хэдийгээр сүүлийн жилүүдэд олон өөрчлөлт гарсан боловч өнөөгийн боловсрол нь ерөнхийдөө социализмын үеийн боловсролын философи, туршлага, оноо болон алдаанд суурилж байгаа гэмээр байна. Социализмын үед давамгайлж байсан боловсролын марксист философиос онцлон дурдмаар зүйл бол нэгд, ерөнхийдөө конструктивист чиглэлтэй байсан, хоёрт, бие хүний болон нийгмийн хөгжлийн тухай асуудлыг салгадаггүй, өөр хооронд нь холбоотой авч үздэг байсан, гуравт, хүний идэвхит чанарыг хөгжүүлэхийг эрмэлздэг байсан зэргийг дурдаж болох юм. Боловсролын практик үйл ажиллагаанд байсан шинж чанаруудаас дараах зүйлд анхаармаар санагдаж байгаа юм. Үүнд:

- Боловсролын үнэлэмж өндөр байсан,
- Мэдлэг олгоход илүү анхаарч байв.
- Амьдралаас тасархай, чадвар олгох талаар дутмаг
- Цээжлүүлэх гэх мэт.

Тэгэхээр бидэнд ардын сурган хүмүүжүүлэх өв, социализмын үеийн боловсролын онол, туршлага, дэлхийн боловсролын өөрчлөлтийн чиг хандлага буюу парадигм гэсэн гурван зүйл байна. Энэ гурваас оновчтойг авч, орчин үеийн нөхцөл байдалд нийцүүлэн цэгцтэй үзэл баримтлал болгож чадвал боловсролын үндэсний философи болох болов уу хэмээн бодож байна.

Монголын боловсролын философи агуулгын хувьд төвч, арга барилын хувьд туйлшралгүй байх нь зүйтэй юм. Агуулгын хувьд төвч гэдгийг юу гэж ойлгож байгаагаа тайлбарлая. Боловсролын философи агуулгадаа олон зүйлийг багтааж байдаг боловч өөр хоорондоо ялгарч байгаа зүйл нь ихэвчлэн боловсролын зорилгыг хэрхэн тодорхойлж байгаа нь юм уу гэмээр ажиглагддаг. Ийм байх нь ч зүй ёсны хэрэг байх. Б. Р. Мандель магистрантурт сурч буй хүмүүст зориулсан “Боловсролын философи – Философия образования” гэдэг номдоо боловсролын философи нь “юуг заах вэ?, яаж заах вэ?” гэсэн дидактикийн уламжлалт асуултаас гадна “хэнийг буй болгох вэ?” гэсэн гурав дахь асуултыг нэмдэг гээд “боловсролын философи нь боловсролын зорилго, суурь үнэлэмж, агуулгыг бүрдүүлэх зарчим, чиг хандлагыг судалдаг салбар бөгөөд боловсролын орчин үеийн үйл явцын түүхэн болон нийгмийн нөхцөл дэх хамгийн ерөнхий, чухал хууль зүй тогтол, хамаарлыг судалдаг шинжлэх ухааны чиглэл юм” хэмээн тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолтын эхний хэсэгт байгаа “боловсролын зорилго” болон “суурь үнэлэмж” гэсэн хоёр ойлголт “үндэсний” гэсэн тодотголтой боловсролын философийн гол тодорхойлогч байх болов уу. Тэдгээрээс агуулга, зарчим, чиг хандлага гэсэн бусад бүрдүүлбэрүүд урган гарах ёстой. Жоел Спрингсийн бичсэнээс үзвэл орчин үед боловсролын салбарт дараах үндсэн үзэл суртал ноёрхож байгаа ажээ. Үүнд:

- Даяаршлын үе дэх боловсролын үндэсний үзэл суртал,
- Даяаршлын үе дэх дэлхий дахиныг хамарсан чөлөөт зах зээлд ажиллах хүчнийг бэлтгэх,
- Ёс суртахууны даяаршил зэрэг болно.

Боловсролын үндэсний үзэл суртал нь үндэсний хэл, соёл, үндэсний түүх, үндэстэн төлөвшүүлэх, аюулгүй байдал зэрэг асуудалд чухал ач холбогдол өгнө. Эл үзэл сурталыг даяаршлын давалгаанд автахаас болгоомжилж буй үндэсний адилсал, нэгдэл нягтрал, тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэх сонирхолтой улс орнууд баримталдаг гэж болох юм. Даяаршсан чөлөөт зах зээлд зориулсан ажиллах хүчнийг бэлтгэх үзэл суртал нь стандартчилал, харьцуулагдах чанар, эдийн засаг, технологийн хөгжил, улс орнуудын өрсөлдөөнд эзлэх байр суурь зэргийг чухалчилна. Тийм учраас гадаад хэл, шинжлэх ухаан (STEM), математик зэрэг хичээлд чухал ач холбогдол өгч байгаа юм. Энэхүү үзэл сурталыг Дэлхийн банк, ЭЗХАХБ (OECD)-ын орнууд хүчтэй дэмжиж байгаа ажээ. Энэ нь эдгээр орнуудын эдийн засгаа тэлэх, дэлхийн зах зээлд давамгайлах юм уу ноёрхох байр суурийг эзлэх, чадварлаг ажиллах хүчнийг дэлхий дахины хөдөлмөрийн зах зээлээс олж ажиллуулах бодлоготой холбоотой юм. Түүнчлэн төрөлт багасах, хүн амын насжилт зэргээс үүдэн үндэсний хөдөлмөрийн нөөц багасаж байгаагаар ямар нэг хэмжээгээр холбоотой. Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжлийн улмаас оюуны өндөр чадвартай ажиллах хүчин ихээр шаардлагатай болсон нь дэлхий даяар авьяасын төлөө “дайн” өрнөж байгаа нь ч нөлөөтэй байна.

Харин ёс суртахууны даяаршлын үзэл суртал нь хүний эрх, ардчилал, соёлын олон янз байдал, тогтвортой хөгжил зэрэгт голлог анхаарч байгаа юм. Эл үзэл сурталыг дэмжигч гол байгууллага бол ЮНЕСКО, түүнтэй хамтран ажилладаг ТББ -ууд юм.

Эдгээр үзэл сурталын агуулгыг ажиглавал эхлээд хийж болох дүгнэлт гэвэл эдгээрийн аль нэгийг нь туйлшруулан хэрэглэх нь зохистой биш. Аль алинд нь сайн болон саар тал байгаа бөгөөд үндэсний боловсролын философи юм уу үзэл сурталыг боловсруулахад өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал, хөгжлийн болон аюулгүй байдлын зорилгыг харгалзан алианаас нь юуг, ямар тунгаар авч хэрэглэх, өөриймшүүлэх вэ гэдгийг шийдвэрлэх нь зүйтэй юм. Азийн үсрэнгүй хөгжиж буй олонх орон чухамхүү ийм хандлагыг баримталж байна. Тухайлбал, БНХАУ боловсролын өнөө үеийн философио боловсруулахдаа өрнөдийн орнууд, олон улсын байгууллагуудын үзэл баримтлал, бодлого, социализмын үеийн буюу зөвлөлт маягийн боловсролын туршлага, Күнзийн үзэл санаанд суурилсан өөрийн уламжлалыг харгалзан үзсэн байна. Ингэсэн нь ч үр дүнтэй болсон бололтой. О.А.Береговая-гийн тэмдэглэснээр Хятад улс боловсролынхоо хөгжил дэвшлээр АНУ, Япон болон хөгжингүй бусад орны 100 жилд олсон амжилтыг сүүлийн 30 жилд олсон ажээ (О. А. Береговая, 2019).

Тэгэхээр бид боловсролын зорилготой холбоотойгоор дэлхийн боловсролд ноёрхож байгаа гэж байгаа гурван чиг хандлага буюу үзэл сурталтай нүүр тулж байна гэж болно.

Монголын боловсролын философийн агуулга төвч байх ёстой гэдгийг уламжлалт, социалист, шинэ парадигмууд болон энд дурдаж байгаа үзэл суртлын гурван чиглэлийг харгалзан боловсролын зорилго, суурь үнэлэмжийг тодорхойлох хэрэгтэй гэсэн байдлаар ойлгож байгаа юм. Харин арга барилын хувьд туйлшралгүй гэдэг нь юуг, яаж заахтай холбоотой гэж болох юм.

Мэдлэгийн хүрээ, гүнзгийрлийн тухай асуудал. Социализмын үеийн боловсролын төдийгүй, дэлхийн бусад улсын өмнөх үеийн боловсролыг шүүмжилж байгаа асуудлын нэг нь энэ юм. Сав дүүргэх гэж байгаа юм шиг суралцагчдын толгой руу хэрэгтэй, хэрэггүй их мэдээлэл чихдэг. Эл шүүмжлэл үнэний хувьтай боловч туйлшруулж бас болохгүй юм. Одоо асуудал шийдвэрлэх чадварыг чухал гэж үзэж байна. Яаж ийм чадвартай болох вэ? Нэгд, зохих хэмжээний мэдлэгтэй байж, түүнийгээ янз бүрийн нөхцөлд хэрэглэж сурснаар, хоёрт, асуудал шийдвэрлэдэг стандарт арга барилуудтай болж, түүнийгээ янз бүрийн нөхцөлд хэрэглэх. Миний бодоход хоёр дахь арга нь явцуу бөгөөд, стандарт арга барил амьдралын тохиолдол бүрд тохирохгүй юм. Тэгэхээр суралцагчдад оновчтой хэмжээний мэдлэг олгох явдал бол зайлшгүй юм. Дэлхийн боловсролоор тэргүүлэгч гэгддэг нэлээд улсын сургалтын хөтөлбөрийг үзвэл ерөнхийдөө шинжлэх ухааны салбаруудаар дагнасан хичээлүүдтэй байдаг өмнөх уламжлал ямар нэг хэмжээгээр хадгалагдаж байна. Нөгөө талаар уламжлалт хичээлүүдээс гадна өөр хичээлийг шинээр нэмэх шаардлага гарч байна. Ийм байдлаас гарахын тулд хичээлийг заавал үзэх болон сонгох гэж ялгах, багцлах, ялгаварт сургалт зохион байгуулах гэх мэт янз бүрийн аргаар нэг суралцагчийн судалж үзэж буй хичээлийн тоо, ачааллыг оновчтой болгох арга хэрэглэж байна.

Өмнөх үеийн сургалтын их шүүмжлэгддэг зүйл бол цээжлүүлдэх юм. Ялангуяа боловсролын тухай мэдлэг тааруу хүмүүс янз бүрийн индрээс ингэж “зад” шүүмжлэх нь их. Гэвч цээжлүүлэх нь сургалтын үйл явцын зайлшгүй хэсэг байдаг. Боловсрол бол нэгд, шинжлэх ухааны мэдлэг олгох (The narrow meaning of the concept of education), хоёрт, дасгалжуулах (training), гуравт, нийгэмшүүлэх (socialization or upbringing) зэргээс тогтоно. Тренинг нь ямар нэг үйлдлийг дадал хэвшил болгохын тулд олон дахин давтуулах үйлдэл юм. Цээжлүүлэх нь тренинг юм. Цагаан толгойн үсэг нүдлэх, үржүүлэхийн хүрд цээжлэх, алгебрын 7 томьёог цээжлэх хэрэгтэй. Томьёог цээжлээгүй байж байгаад хэрэг болсон үед нь ном хараад бодлого бодно гэж байхгүй байх. Бурхны шашны сүм хийдүүд банди нарт эхлээд номыг цээжлүүлээд, дараа нь багш нь тайлбарлаад, улмаар дагсал хаяж, мэтгэлцэн мэдлэгээ бататгадаг байна. Ой санамждаа тогтоогоогүй мэдлэгийг ойлгох гэж оролдох нь даавуугүй байж дээл эсгэх гэсэнтэй ижилдүү юм. Хятад, Солонгос зэрэг азийн зарим оронд суралцагчдад мэдээллийг цээжлүүлэхэд анхаардаг байна.

Энэ бүхнийг харгалзан үзвэл монголын боловсролын философи нь ардын сурган хүмүүжүүлэх ухааны өв, социализмын үеийн туршлага болон боловсролын өөрчлөлтийн орчин үеийн чиг хандлагыг бүтээлчээр хослуулах, үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийг онцолсон, глобал зах зээлд мэргэжилтэй хүний нөөц бэлтгэх болон дэлхийн иргэнийг төлөвшүүлэх гэсэн үзэл суртлын гурван зонхилох чиглэлийг харгалзсан байх учиртай болж байна. Тэгэхдээ асуудлыг өргөн хүрээнд авч үзэх учиртай. Боловсрол бол нийгмийн оюун санааны ертөнцийн дүр төрхийн тухай асуудал, түүний соёл-ёс суртахууны үндэс суурийг төлөвшүүлэх тухай асуудал юм. Тийм болохоор ирээдүйн монголын нийгэм ямар байх вэ гэдгээс дүн шинжилгээг эхэлмээр байгаа юм. Эдийн засгийн зах зээлийн харилцаатай, улс төрийн ардчилал бүхий гэж тооцогдож байгаа нийгмүүд ч өөр хоорондоо их ялгаатай. АНУ, ХБНГУ, Япон, Нордын орнуудаар жишээ авахад л энэ нь ойлгомжтой болно. Тийм учраас ирээдүйд монголын нийгэм ямар дүр төрхтэй байх вэ гэдэг нь боловсролын асуудлаар философидохын эхлэл байх болов уу. Бид сүүлийн гуч гаруй жилд энэ тухай бодоогүй болохоор нийгэм маань өнөөдөр тийм ч сайн сайхан дүр төрхтэй харагдахгүй байна.

Эцэст нь, энэхүү философийг боловсруулах аргын талаар саналаа хэлье. Ажиглалтаас үзвэл манайд аливаа асуудлыг боловсруулахад хэрэглэдэг хоёр үндсэн арга байна. Нэгд, ажлын хэсэг томилж ажиллуулах, хоёрт, хэлэлцүүлэг явуулах. Энэ хоёр аргын аль аль нь сайн ба муу талтай учраас хослуулах хэрэгтэй. Үүнд:

- Зориудын төсөл хэрэгжүүлэх. Мэргэжлийн хүмүүсийг цалинжуулж ажиллуулах. Цалин олгохгүйгээр мэргэжлийн хүмүүсээр ажлын хэсэг байгуулж ажиллуулах тохиолдолд хүмүүс

тухайн төсөлд зориулсан судалгааг зориуд хийхгүйгээр өмнө нь хуримтлуулсан мэдлэг, туршлагаа ашиглан уг ажлыг “цээжний бангаар” хийх нь элбэг байдаг.

- Төслийн үр дүнгээр гарсан философи юм уу номлолыг ямар нэг хэмжээгээр хэлэлцүүлэх. Хэлэлцүүлгийн үр дүнг тусган дахин боловсруулах, туршилт хийх
- Улс төрийн хүрээнд нийт үндэсний зөвшилцөлд хүрэх зэрэг юм.

Дэлхийн улс орнуудад иймэрхүү ажлыг Үндэсний хороо байгуулж, тодорхой цаг хугацаа эзлүүлэн буурьтай хийдэг туршлага бий. Боловсрол бол улс орны, хувь хүний хувь заяанд нөлөөлдөг, өөрчлөлтийн үр дүн нь олон жилийн дараа гардаг, хүн болгон мэддэг юм шиг атлаа яг мэддэг хүн бараг байдаггүй шахам нарийн төвөгтэй салбар юм. Тиймээс боловсролын бодлого гаргах ажлыг яаруу сандруу, “субботник”-ээр хийж болохгүй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бат-Очир, Б. (1992). Мандах нарны туяа хэмээх сургаал. Эрх. Б.Дашзэвэг, Улаанбаатар.

Лувсандорж, Ж. (1970). Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн нэгэн зарчим. *Сурган хүмүүжүүлэгч №2*.

(1965). Манжийн дарангуйллын үеийн Монголын сургууль. Улаанбаатар.

(1966). Монголын Автономит үеийн сургууль. Улаанбаатар.

Пунсаг, А. (2003). Монголчуудын уламжлалт цээрийн ёс. Ред. З.Лонжид Улаанбаатар.

Цанжид, А. (2022). Уугуул монгол соёл. Улаанбаатар.

Эрдэнэ-Очир, Г. (1979). Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлалаас. Улаанбаатар.

Береговая, О.А. (2019). Китайская философия образования: между традицией и модернизацией. <https://doi.org/10.24158/fik.2019.5.6>

Мандель, Б.Р. (2017). Философия образования. Москва.

Barrow, Robin. (2021). An Introduction to Philosophy of Education 3-rd ed. 2005, 5-th ed. Routledge.

Springs, Joel (2015). Globalization of Education, Routledge, 2-d ed.